

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ, МЭДЭЭЛЭЛ

**ТҮҮХИЙН ДУРСГАЛЫН СУДАЛГААНЫ
ҮР ДҮНГЭЭС**

Монголын ард түмний эртний түүхийн олон чухал асуудлыг судлан шинжлэхэд Монгол, Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедици ихээхэн хувь нэмэр оруулсаар байна. Дээрх экспедицийн чулуун зэвсгийн судлах анги Дундговь аймгийн Өндөршил, Гурван сайхан сумын заагт орших Ярх уулнаас хуучин чулуун зэвсгийн доод үед холбогдох зэвсэг багаж болох шар, шаргал хаш, цахиураар хийсэн дугараг гурвалжин хэлбэрийн зэвсэг, хусуур зэргийг олж шинжилсэн нь манай оронд одоогоос 400000-300000 жилийн өмнө хүмүүс оршин амьдарч байсныг харуулах нээлт болсноороо онцлог бөгөөд ач холбогдолтой юм.

ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн А.П.Деревянкогийн удирдсан чулуун зэвсгийг судлах анги нь VI таван жилд Баянхонгор, Өвөрхангай зэрэг аймагт жил дараалан шинжилгээний ажил хийж палеолит, мезолит, неолитын үеийн 20 гаруй шинэ бууц суурин олж илрүүлсэн бөгөөд өнгөрөгч 1984 онд тус улсын баруун хэсэгт ажиллаж чулуун зэвсгийн 104 пункт газрыг олж илрүүлэв. Одоогоос арваад мянган жилийн өмнө манай оронд соёл иргэншлийн ихээхэн ул мөрийг үлдээн амьдарч байсан шинэ чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн түүхийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болсон чулуун онго Дорнод аймгийн Булган сумын Норовлин уулнаас олдсон юм. Энэхүү чулуун онго бол монгол нутгаас урьд өмнө олдож байгаагүй бөгөөд зах зэргэлдээ орон нутагт ч ижилсэх хувьгүй байгаагаараа онцлог учир ховор олдворт зүй ёсоор тооцогдож байна.

Монгол, Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедиц нь VII таван жилд манай орны эртний түүхийг судлан боловсруулах талаар чамлалтгүй үр дүнд хүрч байна.

Экспедицийн хүрэл, төмрийн үеийн дурсгал судлах анги Увс аймгийн төвийн ойролцоо оршин Чандмань уулын орчимд Төв Азийн төмөр зэвсгийн үеийн талаар зохих хэмжээний дүгнэлт хийж, түүний ерөнхий шинж байдлыг тодорхойлох булш, оршуулгуудыг олж залуу эрдэмтэн Д.Цэвээндорж эрдэм шинжилгээний чухал дүгнэлт хийлээ. Өгүүлэн буй шинжилгээний анги археологич Д.Навааны удирдлагаар 1981 онд Туул голын хөндийд ажиллаж, 13, 14-р зуун үед хамаарагдах нэгэн булш малтсан юм. Уул булшинд модон иштэй төмөр хутга, үйсэн хоромсого, төмөр зэв, дөрөө зэргийг тавьснаас гадна уг хүнд алтан тоног бүхий бүс дагалдуулсан байлаа. Манай орны археологичид мэргэжил нэгт зөвлөлтийн нөхөдтэй хамт өөрийн орны хүй нэгдлийн байгууллын үед хамаарах археологийн баялаг хэрэглэгдэхүүн болох “буган чулуун хөшөө”-г 450 гаруйг олж судлав.

Монгол нутагт оршин амьдрагчид эрт цагт нүүдлийн мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ хот суурин байгуулж, хот байгуулалтын талаар өндөр мэдлэг бүхий ард түмэн байсныг археологийн судалгааны үр дүнд олж илрүүлсэн 300 гаруй хот суурин харуулж байна. 1983 онд хүрэл, төмрийн үеийн дурсгал судлах анги Булган аймгийн Бүрэгхангай сумын Өвгөнт уулын өвөрт эртний нэгэн булшийг малтаж 3 см диаметр бүхий хүний дүрст үсэгтэй алтан эдлэл, 39 ширхэг моголчуудын бичиг үсгийн дүр төрхийг харуулахуйц ховор олдвор болсон юм. Өнгөрсөн VI таван жилд бичээс судлалын анги Булган, Говь-Алтай, Дундговь зэрэг аймагт хайгуул хийж эртний руни бичигтэй хөшөө хоёрыг шинээр олж, бага бичээч арван хоёрыг нягтлан уншсанаас гадна олон тооны уйгар, монгол, согд бичээсүүдийг олж судаллаа. Энэхүү бичгийн дурсгалууд нь Төв Азид эртнээс нутаглан суусан аймаг угсаатан, улс түмний, ялангуяа монголчуудын өвөг дээдсийн эртний болон дундад эртний үеийн түүх, соёлыг судлахад онцгой чухал хэрэглэгдэхүүн болов.

Залуу археологи Д.Баяр сүүлийн жилүүдэд тус орны дорнод хэсэгт өвөрмөц сонин хийц бүхий 50 орчим хүн чулууг судлан шинжилж, монголчуудын эдийн боловсролын талаар сонирхолтой дүгнэлт хийж байна. Мөн өнгөрөгч оны зун манай археологчид Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Айд уулын орчимд нэгэн булшийг малтан шинжилж, ланз бүсэг бүхий сонин олдвор олсон нь дундад зууны үед холбогдох археологийн чухал хэрэглэхүүнд зүй ёсоор тооцогдож байна. Ийнхүү Монголын ард түмний эртний түүхийн дурсгал судлан шинжлэх ажил жилээс жилд улам арвижин өргөжсөөр байна.

Х.Лхагвасүрэн